



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 09 сарын 09 өдөр

Дугаар 1/1660

Улаанбаатар хот

Сонгинохайрхан дүүргийн 163 дугаар
цэцэрлэгийн эргэлтийн бус хөрөнгийг
данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2021 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 15,520,387 (арван таван сая таван зуун хорин мянга гурван зуун наян долоо) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Сонгинохайрхан дүүргийн 163 дугаар цэцэрлэг (М.Уранчимэг)-т зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 3 нэр төрлийн 14,393,757 (арван дөрвөн сая гурван зуун ерэн гурван мянга долоон зуун тавин долоо) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор зохих журмын дагуу устгалын акт үйлдэн устгах, 3 нэр төрлийн 1,126,630 (нэг сая нэг зуун хорин зургаан мянга зургаан зуун гуч) төгрөгийн хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар 40,000 (дөчин мянга) төгрөгөөр худалдан борлуулж, орлогын 30 хувь болох 12,000 (арван хоёр мянга) төгрөгийг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын төрийн сангийн 100200051024 тоот дансанд шилжүүлэхийг Сонгинохайрхан дүүргийн 163 дугаар цэцэрлэг (М.Уранчимэг)-т, орлого төвлөрүүлэхэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс (М.Мандах)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА

115050000783



Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2021 оны 09 дугаар сарын 09 өдрийн 09/163 дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Сонгинохайрхан дүүргийн 163 дугаар цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Бүгд үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Эвдрэл гэмтэл	ӨХЗ-ийн дүгнэлт	Байгууллагын үнийн санал нэг бүрийн үнэ	НӨАУГ-ын мэргэжилтний үнийн санал
Нийтийн эзэмшил												
1	Явган хүний шигтгэмэл хавтан зам	3	м3	83	34,629.00	2,874,207.00	479,034.49	2,395,172.51	Эвдрэл гэмтэл ихтэй	ашиглах боломжгүй хуулж аваад дахин хучсан	устгах	устгах
2	Нийтийн зориулалттай талбай	3	м3	600	8,072.75	4,843,650.00	2,018,187.60	2,825,462.40	Эвдрэл гэмтэл ихтэй	гэмтэл ихтэй тэгшлээд дээрээс нь хучсан	устгах	устгах
3	Тоглоомын талбай	3	м3	60	111,265.00	6,675,900.00	5,563,250.10	1,112,649.90	Эвдрэл гэмтэл ихтэй	гэмтэл ихтэй ашиглах боломжгүй	устгах	устгах
4	Гадна талбайн төмөр тоглоом	13	ш	5	200,000.00	1,000,000.00	1,000,000.00	-	Эвдрэл гэмтэл ихтэй	ашиглах боломжгүй	30,000	30,000
5	Төмөр гулсуур	29	ш	1	36,180.00	36,180.00	36,180.00	-	Эвдрэл гэмтэл ихтэй	ашиглах боломжгүй	5,000	5,000
6	Төмөр гулсуур	28	ш	1	90,450.00	90,450.00	90,450.00	-	Эвдрэл гэмтэл ихтэй	ашиглах боломжгүй	5,000	5,000
Нийтийн эзэмшлийн дүн						15,520,387.00	9,187,102.19	6,333,284.81			40,000	40,000
Нийт данснаас хасах хөрөнгийн дүн						15,520,387.00						
Үүнээс: Худалдах хөрөнгө						1,126,630.00						
Устгах хөрөнгө						14,393,757.00						
Худалдсанаас олох орлого											40,000	40,000
НӨАУГ-т төвлөрүүлэх /30 %/											12,000	12,000